

**Агвандандарын “Үүрийн шинэхэн туяа” хэмээх
толь бичиг дахи шүлгүүдийн тухай**

Д.Бүрнээ (МУИС)

XVIII-XIX зууны монголын эрдэмтэн Агвандандар (1759-1840) гурван зүйлийн толь бичиг туурвисан боловч түүний сүмбүмийн гарчигт “Сарны гэрэл” хэмээх төвд монгол дохионы бичиг л орсон байдаг. Тэрээр “Сарны гэрэл”-ээс гадна “Цастны шинэ хуучин дохионоос туурвисан даяг, саруул оюутны хоолойн чимэг” (Gangs can gyi brda' gsar rnying las brtsams pa'i brta' yig blo gsal mgrin rgyan ces bya ba bzhugs so) хэмээх төвд хэлний шинэ хуучин дохионы толь болон “Эндүүрлийг тэвчих сайн номлол үүрийн шинэхэн туяа” хэмээх хураангуй толь (dag yig gces bsdus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so)-ийг зохиосон билээ.

Агвандандарын зохиосон “Эндүүрлийг тэвчих сайн номлол үүрийн шинэхэн туяа хэмээх хураангуй толь” нь Гүмбүм хийдэд бартайгаас гадна гар бичмэлээр тархсан байна. Бидний цуглуулгад буй гар бичмэл бол орос цаасан дээр дөрвөн мөрөөр, хар бэхээр бичсэн 11.5x44.3 см хэмжээтэй, хорин таван хуудас судар юм. Судрын нүүр бүрт балын харандаагаар шугам татан, орчуулгыг хадахаар бодсон бололтой, мөр хооронд нэлээд зай гаргаж, энд тэнд алдаг оног зарим орчуулга хийсэн байна.

Төгсгөлийн үгэнд “эндүүрлийг тэвчих сайн номлол үүрийн шинэхэн туяа хэмээх хураангуй толь энэ нь эртнээс найруулсан янз бүр байсны дээр зарим бээр ч дурдан сануулсан ёсоор Лхасын дацан бүгдэд дамжаа тавигч (Lha ldan grwa skor ba'i ming can) нэрт Алагшаа газрын хязгаарт төрсөн эгэл хүмүүн Агвандандар бээр найруулсан болой. Үүгээр ч ялгуусан шашин эрдэнэ өнөд дэлгэрэх болтугай хэмээсэн үүнийг Гүмбүм Жамбалингийн бард бүтээв” гэжээ.¹

Төгсгөлийн үгээс үзвэл уг толийг Агвандандар зохиосон нь тодорхой байна. Нөгөөтэйгүүр, Агвандандар энэ толио төвд хэлний зөв бичих дүрмийн бусад толь бичгийг нягтлан үзэж, шинэ тутам үйлдсэн бололтой. Төвд хэлний зөв бичих дүрмийн энэ төрлийн толь цөөнгүй байлаа ч олны зүгээс түүнийг шинээр хийхийг хүссэн нь өмнөх толиуд зарим талаар бас уншигчдын хэрэгцээг хангахгүй болж ирсэнтэй холбоотой гэж үзмээр байна. Цаашилбал уг бичмэл судрыг Гүмбүм хийдэд барласан судраас хуулбарлажээ. Бүтцийн тухайд авч үзвэл уг толь арван хэсэгтэй. Үүнд толгойт, зүүлтэт, угталгат, дахин орсон дагавар авсан бичлэг өөр, бас утгын талаар ч ялгаатай үгсийг цагаан толгойн дарааллаар байрлуулж, хэсэг бүрийг тус тус нэрлэсэн байна.

Тухайлбал нэгдүгээр хэсгийг “Толгойт үсэгт эндүүрсэнийг тэвчих нь”, хоёрдугаар хэсгийг “Зүүлтэтийн эндүүрлийг тэвчих”, гуравдугаар хэсгийг “Угталгат үсгийн эндүүрлийг тэвчих” гэх зэрэг нэрлэсэн нь үг, үсгийг буруу бичиж эндүүрэхийн гэмийг арилгахыг зорьсон нь харагдаж байна. Наймдугаар хэсэгт зөв бичих дүрмийн талаар маргаантай үгсийг сонгон оруулж өөрийн саналыг хэлжээ. Тухайлбал төвдөөр “Самадог”, монголоор “Хуурцаг”, төвдөөр “Агдон”,

¹ Dag yig gces bsdus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, 25а.

монголоор "Хэлний зул" зэрэг төвд хэлний зөв бичих дүрмийн хоёр үндсэн толь бичгийг харьцуулан үзэж, тэдгээрт орсон зарим үг зөв бичилгийн талаар зөрж буйг тэмдэглээд нягтлах нь зүйтэй гэжээ. Түүнчлэн төвд хэлний зөв бичих дүрмийн тольд орсон зарим үгийн бичлэг төвд хэлний зүйг зохиосон Томи Самбодаагийн "Гучит" хэмээх хэл зүйн бичгийн дүрэмтэй харшилж буйг ч шүүмжилсэн байна. Агвандандарын зохиосон энэхүү толь бичиг түүний бүтээсэн бусад хоёр толиос ялгагдах онцлог нь толь бичгийн эхэн болон завсар хооронд бичсэн олон шүлэг юм.

Энэ нь толь бичиг судлалын зэрэгцээгээр яруу найраг зүйн гүн нарийн учир холбогдолтой болохыг харуулж байна. Бид энэ удаа тус толийн шүлэглэлийн тухайд та бүхэнд мэдээлэх ялдамд цөөн зүйлийг хэлэхийг хүснэ. Агвандандар шүлгээ зохист аялгууны утгын гучин таван чимгээр шүлэглэсэн бөгөөд ингэхдээ бадаг бүрийн эхэнд ямар чимгээр бичсэнээ дурджээ. Тухайлбал тахилын болон төгсгөлийн шүлгийг зохист аялгууны өлзий өгүүлэхийн чимэг, үлгэрийн чимэг, дүрстийн чимэг тэргүүтнээр шүлэглэжээ.

Тухайлбал:

Өлзий өгүүлэхийн чимгээр:

*Rgyal kun 'phrin las mdzes sdug lha mo yi
Rnam pa'i gar bsgyur rje btsun sgrol ma dang
Gnyis med klong rdol ngag dbang blo bsang la
Skyabs su mchi'o kun du shis gyur cig*

Ялгуугсан бүгдийн бүтээл үйлсээр үзэсгэлэн төгөлдөр охин тэнгэрийн
Ялгуум дүрээр хувилан бүжих богд Дара эх хийгээд
Ижил үгүй Лондол Агван Лувсан багштанаа
Итгэл аврал явуулъя, өлзий орших болтугай²

хэмээн Дара-эх хийгээд өөрийн номын багш Агван Лувсан нартаа залбиран өлзий хутгийг гуйн шүлэглэжээ.

Магтахын чимгээр бичсэн шүлэгтээ:

*Dus gsum rgyal ba mtshan dpe yongs su rdzogs
Bdag gi bshes gnyen mgrin pa'i mdud bkrol tsam
De lta na yang rgyal ba kun dngos dang
Gnyis med klong rdol ngag dbang blo bzang la
skyabs su mchi'o kun tu shis gyur cig.³*

Гурван цагийн ялгуугсан бурханы лагшин найраг огоот төгссөн
Гавьяат миний буяны садан хоолойн зангилааг тайлах төдий
Гойд ялгуугсан хотол хамаг бодосоос.
Гагцаар ялгарах хосгүйг мэдэж бишрэн шүтмүй

хэмээн өөрийн багшийг гурван цагийн хамаг бурхадтай зүйрлэн магтахын сацуу хотол олноос онцгойрон ялгарах билгүүн их эрдэм төгссөнийг магтан шүлэглэжээ.

Бодот адилтгалаар бичсэн нь:

*nyin byed stong gis 'khyud pa'i 'o mtsho yis
lan brgyar byugs pa'i shel gyis 'dzin da kyang
gang gi dkar mdzes dpal la mi bzod pa'i
dbyangs can lha mo mgrin par rtag roi da cig⁴*

² Dag yig gces bsodus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, rap бичмэл судар, 1а.

³ Dag yig gces bsodus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, rap бичмэл судар, rap бичмэл судар, 1а.

⁴ Dag yig gces bsodus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, rap бичмэл судар, rap бичмэл судар, 1а.

Мянган нараар тэврүүлсэн нуурын усан хийгээд
Мэлтрэх болроор зуу дахин өнгөлж барьсан боловч
Эгнэгт гэгээн цагаан үзэсгэлэнт цогийг үл хүлцэх
Эгшигт охин тэнгэр насад хоолойд цэнгэх болтугай

хэмээн яруу найргийн увидасыг соёрхогч Янжинлхамын үзэсгэлэн төгөлдөр лагшинг мянган
нарны гэрэл хийгээд тунгалаг болортой адилтгаж, Янжинлхамын энэхүү “алимадын үзэсгэлэнг
үл хүлцэх” хосгүй гайхамшигт гоо үзэсгэлэнг магтан дуулахын сацуу эгшигт охин тэнгэрээс яруу
өгүүлэхийн шидийг хүсэн гуйж залбирсан байна.

Ялгал үлэмж хэтэрхий болсон чимгээр бичсэн нь:

*srin pos bzung ba'i mtha' 'khob gangs ljongs su
bka' bstan 'gyur ba'i thabs su bod yig srol
byed po sa 'bo ra yi bka' drin mtha'
khyab 'jug gnas kyis gzhal bar mi nus so⁵*

Мангас бээр барьсан хязгаар орны цаст шилтгээнээ
Магад зарлигийг орчуулахад төвд бичгийн журмыг үйлдсэн
Төв сууринг байгуулахад ямааны тусын хязгаар болсон
Тэнгэрийн олон орон бээр ч үлэж үл чадах нэгэн болой

хэмээсэн энэхүү шүлэгт төвд орны гарал үүсэл хийгээд орон хийдийг байгуулсан домгоос үүдэн
бичжээ. Тухайлбал төвд орны гарал үүслийг мангастай холбож тайлбарласан домог хийгээд
Лхасын Расапрүлнан хийдийг барихад ямаагаар шороо зөөж байсан гэдэг домог тэргүүтнийг
үндэс болгожээ.

Хувьсын дүрстээр шүлэглэсэн нь:

*Bod yig gis bskrun gtsug lag nam mkha'i nor
Thugs rje rta bdun rol pas rab dwangs nas
Thub bstan pad ma'i srog zungs gso mdzad pa'i
Gna' po'i chos rgyal lo pan mams la dad⁶*

Судар шастирыг төвд бичгээр бүтээсэн нь огторгуйн чандмани
Сайтар гийгүүлэх нигүүлсэхүйн долоон мориор огоот цэнгэснээр
Тэжээн зохиох чадагчийн шашны лянхуан амийг барих
Тодрон гийсэн номын хаад хэлмэрч бандидад сөгдмүй

хэмээн ертөнцийг гийгүүлэх гэгээн наран байгаль дэлхийг тэжээн тэтгэдгийн адил эртний
номын хаад, хэлмэрч мэргэдийн бүтээсэн судар шастир энэрэн нигүүлсэх утга агуулга төгссөний
учир бурханы шашныг дэлгэрүүлэн тэтгэдэг хэмээн ертөнцийг гийгүүлэх нарыг мэргэдийн
бүтээсэн судар шастиртай зүйрлэж магтсан байна. Энэхүү шүлэгтээ бусад олон шүлгийн адил
илт өгүүлэх нэр буюу ёгт нэрийг түгээмэл хэрэглэсэн байх бөгөөд зөвхөн энэ шүлэгт гэхэд л
нарыг огторгуйн чандмани, долоон морь, лянхуан амь гэх зэрэг ёгт нэрээр нэрлэжээ.

Үйлийн мөн чанарыг өгүүлэх чимгээр:

*Gang gi tshad med thugs rje gyo tsam gyis
rmaḍ byung myur ba'i spobs pa ma 'bod par
bde slag ster ba'i klog gi slob dpon drin
da gzod dran nas drin gzo'i bsam pas bsten⁷*

⁵ Dag yig gces bsduḥ 'khrul spong legs bshad skya reṅgs gsaṅ ba zhes bya ba bzhuḡs so, rap бичмэл судар, rap бичмэл судар, 1a.

⁶ Dag yig gces bsduḥ 'khrul spong legs bshad skya reṅgs gsaṅ ba zhes bya ba bzhuḡs so, rap бичмэл судар, rap бичмэл судар, 2a.

Алимадын цаглаш үгүй нигүүлсэхүй хөдлөх төдийгөөр
Ашидын түргэн билиг чадал эс дуудахуйд
Амар хялбар соёрхох уншилгын багшийн ачийг
Авад санаж ямагт хариулахыг шамдан шүтэх

хэмээн бурхан бодьсатвын энэрэн нигүүлсэх сэтгэл хийгээд билиг төгөлдөр оюутны санаа бодол агшин зуурын төдий төрдөгийн адил номын багшийн ачийг дурсмагц даруй ачийг нь хариулахыг хоромхон зуур санадаг тухай өгүүлсэн байна.

Хураахын дүрстийн чимгээр бичсэн нь:

*dpyad kyang the tshom mun pas bcud ma myong
nyes bshad 'dab ma brgya yis btum pa'i nang
blo gsal rkang drug 'phur 'dod skad zhan na
legs bshad skya rengs gsar ba 'di skugs shig*

Хэдий шинжлэвч сэжгийн мунхагаар шимийг үл амсах
Хирт номлолын зуун навчаар битүүлсэний дотор
Саруул оюутны зургаан хөлт зөгий нисэхийг хүсч дуун суларваас
Сайн номлолын үүрийн шинэхэн туяа энэ мөрий тавих болтугай⁸

хэмээн алдаа мадагтай бичиг зохиолыг шимгүй өвс ургамалтай зүйрлэхийн сацуу танин мэдэж ухаарч ойлгохыг хүсэвч учрыг олохгүй төөрөн будилагсадыг зуун навчинд хучигдан дуу нь суларсан зөгийтэй давхар зүйрлээд өөрийн бичсэн “Үүрийн шинэхэн туяа” хэмээх толио эндүүрлийн гэмийг арилгаж зөв замаар замнахад тус дэм үзүүлэхийг уран яруу утга төгөлдөр өгүүлсэн байна.

Ийнхүү удиртгал болон нэгдүгээр хэсгийн оршил шүлэгт эртний номын хаад, хэлмэрч орчуулагч нар хийгээд бандид нарын зохиосон бүтээл туурвил бурханы шашныг дэлгэрүүлэн хөгжүүлсэнийг магтан дурсахын хамт багшийн ач тусыг нэхэн санагалзаж, багшийг шүтэх зохистойг өгүүлсэн есөн бадаг шүлэг бичжээ. Энэчлэн хоёрдугаар хэсгийн эхэнд зохист аялгууны дүрстийн чимэг, үлгэрийн чимэг, шалтгааны чимэг тэргүүтнээр шүлэг бичсэн бол гуравдугаар хэсгийн эхэнд зохист аялгууны утгын чимгээс үлгэрийн чимэг, маш гүтгэхийн чимэг, гийгүүлэгч чимэг, няцаах чимгээр, дөрөвдүгээр хэсгийн оршлыг харшлах, адилтган найруулах, бусад утгыг байгуулах зэрэг утгын чимгээр шүлэглэжээ.
Тухайлбал:

Зохисын шалтгааны чимгээр бичсэн нь:

*mtshan nid ldan pa'i bshes gnyen dam pa mchog
bsam dang sbyor bas bsten tshul ma log pas
tshul 'di 'chad dang rtsom la 'jug pa la
'tsher med smra ba'i spobs pa gzengs su mtho⁹*

Буяны садан дэгээд бэлгэ чанар төгсөгсөн
Барилдлага хийгээд санаагаар шүтэх ёсон эс урваснаар
Сайхь ёсыг номлох хийгээд туурвихад ороход
Самбаа гарган аюумшиг үгүй өгүүлэх их урамтай

хэмээн буяны садан мэргэд дээдэс буяны мөрөөр гуйвалт үгүй замнаж, буяны садан багшийг зүй зохистой шүтэж, хичээл билгийг гаргаж шамдаснаар бурханы номыг номлон чадах хийгээд гэм нүглийг тэвчиж зөв мөрөөр замнасны ачаар айх эмээхийн зовлонгоос ангижрах буюу

⁷ Dag yig gces bsds 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, гар бичмэл судар, 2а.

⁸ Dag yig gces bsds 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, гар бичмэл судар, 2а.

⁹ Dag yig gces bsds 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, гар бичмэл судар, 5а.

мэргэдийн дэргэд санаа амар суух эрхтэй хэмээн буяны мөрөөр чигч шударгаар замнахын ач тусыг өгүүлжээ.

Дүрстийн дүрстийн чимгээр бичсэн нь:

*legs bshad rdzin bu che rkyes dga' tshal 'dir
blo gsal ngang mo rag gi gnyis pa'i tshogs
mi shes dri 'khrud sbrang rtsi'i 'thung bzhin du
rtsed 'jo'i 'phur lding rol pas dus 'da' rigs¹⁰*

номлолын цөөрмийн лянхуа баясах цэцэрлэг үүнд
Саруул оюут галуу шүтэх хоёрын чуулган
Эс мэдэхийн хирийг угаах балын ундаа мэт
Эрхлэн цэнгэж нисэн дүүлсээр цагаас нөгчих нь зохистой

хэмээн сайн номлол сургаалыг сонсож дуулсан гэгээн мэргэд үл мэдэхийн мунхагийн харанхуйгаас гэтэлж, сэтгэлийн цэнгэл баясалыг эдэлж, эцэст наснаас нөгчих жамтайг өгүүлэхдээ сайн номлолоо олныг баясах лянхуа цэцгийн цөөрөмтэй, саруул оюут мэргэдийг нууранд шүтэх галуу шувуудтай, үл мэдэхийн хирийг арилгаж гэгээрлийг олж улмаар баясан жаргаж буй мэргэдийг балын амтыг амталж наадан цэнгэж буй галуу шувуутай зүйрлэжээ.

Энэхүү шүлэгтээ дүрстийн чимэг хийгээд шалтгааны чимгийн найруулах аргыг хослон хэрэглэж, саруул ухаант мэргэд билиг эрдэмийн шимийг хүртэж баясах нь зохистой, харин галуу шувууны хувьд балын амтыг амталж баясах нь зохистой хэмээн баясан цэнгэхийн зүй зохист шалтгаан бүрдсэнийг уран яруу өгүүлжээ. Агвандандарын шүлгүүдэд түүний буддын шашныг шүтэж дээдэлдэг үзэл бодол, буддын шашны гүн ухаанч үзэл, цаашилбал багшийг шүтэж биширдэг үзэл тодорхой харагдахаас гадна түүний ёс зүй болоод гоо сайхны үзэл бодол ч ил тод харагдаж байна. Нөгөөтэйгүүр төвд бичиг үсгийн дүрмийг засан сайжруулах, нэг мөр болгож журамлах үзэл санааг түүний шүлгүүдээс харж болох байна. Тухайлбал есдүгээр хэсгийн “Нэгэн нэр олон утгад орохыг шинжлэх” гэсэн хэсгийн оршилд бичсэн нь:

*dag yig mams kyi yi ge mthun min de/
byed po so so'i yul skad yin nam ci/
yang na khyad med gdam nga yin pa 'am/
dag gi yid ni the tshom dpyad thag 'dzin*

Толь бичгүүдийн үсэг зохилдох бус тэр нь
Тийн зохиогч тус тусын орны хэл буюу юун
Тийм бус аваас ялгалгүй сонгох буюу
Тээнэгэлзэн шинжилж байна миний сэтгэл¹¹

хэмээн төвд хэлний зөв бичгийн дүрэм хоорондоо зөрдөгийг толь зохиогчидын хэл аялгууны нөлөөтэй холбож үзжээ.

Ийнхүү Агвандандар төвд хэлний зөв бичих дүрмийн энэ тольдоо төвд хэлийг сайтар шинжилж хэл зүйн нарийн төвөгтэй бас маргаантай асуудлыг шүүн тунгаасан нь төвд хэл зүйн дүрмийг сурч судлах хүмүүст таатай гарын авалга болсон бүтээлч ажил байсан байна. Толь бичиг зохиох нэр чимхлүүр ажлынхаа завсар чөлөөнд бичсэн жар орчим шүлэг нь Агвандандарын урын санг судлахад чухал ач холбогдолтой байна. Агвандандар зохист аялгууг судалж тусгайлан гурван зохиол туурвихын сацуу ийнхүү гүн утгатай, яруу хэллэгтэй найраг бичиж байсан нэгэн жишээг энэхүү толиос бас давхар харж болох байна.

¹⁰ Dag yig gces bsdus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, гар бичмэл судар, 5а.

¹¹ Dag yig gces bsdus 'khrul spong legs bshad skya rengs gsar ba zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, гар бичмэл судар, 11 а.

ABSTRACT

On specific feature of Agvandandar's dictionary "A new dawn"

A famous Mongolian scholar Agvandandar (1759-1840) wrote three kind of dictionaries. His Tibetan-Mongolian dictionary "Moon light" was popular among Mongols and Tibetans during long time and nowadays this work is studied by scholars in some levels. But the dictionary "A new dawn" (Skya rengs gsar ba) was not included in list of his works and not studied until nowadays. In this paper we considered the specific feature of this dictionary compiled in Tibetan. The dictionary consists of 10 parts and in each part Agvandandar considered orphographical features of Tibetan grammar and as a poet at the beginning and the end of his explanations he wrote verses using the Poetry theory of Dandin's Kavyadarsha.